



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/180/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг:
Ахлах аудитор: С.Гансүх
Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn
Ньюбаланс Аудит ХХК-ийн
Захирал: Цахим хаяг : newbalance.lhagvaa@gmail.com
Утас: 99101901
Чанарын хяналтын менежер: Д.Гэрэлчулуун
d.gerlee98@gmail.com
Аудиторын туслах: Д.Балжинням d.baljii73@gmail.com
Утас: 86267997

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.09.25 № 01/223
танай -ны № -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Э.БАТБААТАР
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>157,127,893.98</u>	<u>172,999,324.26</u>
33	АВЛАГА	4,186,600.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,012,600.00	00.00
335	Бусад авлага	2,174,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	2,174,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	152,941,293.98	172,999,324.26
351	Түүхий эд материал	9,756,065.00	8,188,017.00
35110	Тусгай зориулалттай материал	4,346,065.00	4,005,350.00
35130	Эм боох материал	5,410,000.00	4,182,667.00
354	Хангамжийн материал	143,185,228.98	161,281,307.26
35410	Бичиг хэргийн материал	7,130,683.00	3,180,267.00
35420	Аж ахуйн материал	65,814,934.65	76,438,334.65
35440	Түлш, шатах тослох материал	30,000,000.00	9,995,000.00
35450	Барилгын засварын материал	3,609,065.00	22,828,665.00
35460	Хүнсний материал	5,776,215.00	13,564,810.00
35470	Бусад хангамжийн материал	30,854,331.33	35,274,230.61
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,403,853,153.72</u>	<u>2,328,065,529.36</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,403,853,153.72	2,328,065,529.36
392	Биет хөрөнгө	1,344,219,070.29	2,269,731,445.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,223,752,259.00	2,134,061,298.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-133,643,209.44	-152,845,420.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,746,018.00	14,746,018.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,746,018.00	-14,746,018.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	225,054,032.80	168,506,539.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-166,993,550.15	-79,883,814.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125,901,625.61	157,555,877.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-62,463,126.34	-61,900,310.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	105,909,928.00	104,935,428.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,467,833.50	-21,690,837.10
39217	Ном	38,168,944.31	20,992,685.37
393	Биет бус хөрөнгө	59,634,083.43	58,334,083.47
39301	Програм хангамж	7,437,000.00	7,287,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,484,916.57	-4,634,916.53
39303	Бусад биет бус хөрөнгө	55,682,000.00	55,682,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,560,981,047.70</u>	<u>2,501,064,853.62</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,560,981,047.70</u>	<u>2,501,064,853.62</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,560,981,047.70	2,501,064,853.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,063,809,088.69	1,063,809,088.69
51101	Өмч: - төрийн	1,063,809,088.69	1,063,809,088.69
512	Хуримтлагдсан үр дүн	87,732,098.66	1,069,569,102.58
51210	Өмнөх үеийн үр дүн	87,732,098.66	129,485,296.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	940,083,805.92

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	409,439,860.35	367,686,662.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,560,981,047.70	2,501,064,853.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,270,329,387.26	2,177,592,008.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	124,418,087.26	2,118,272,319.86
120	Нийтлэг татварын бус орлого	124,418,087.26	1,042,993,019.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	124,418,087.26	1,042,993,019.86
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	124,418,087.26	1,042,993,019.86
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	1,075,279,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	1,075,279,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	87,503,100.00	59,319,688.82
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,058,408,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,174,000.00	4,933,588.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,933,588.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,174,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,329,100.00	54,386,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,329,100.00	54,386,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,157,097,573.56	1,189,831,959.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,157,097,573.56	1,189,831,959.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,108,654,318.98	1,155,471,437.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	812,494,794.92	830,969,893.00
210101	Үндсэн цалин	682,179,511.00	560,157,999.00
210102	Нэмэгдэл	69,885,630.00	216,779,670.00
210104	Урамшуулал	60,429,653.92	54,032,224.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,614,300.00	111,990,100.00
210201	Тэтгэврийн даатгал	75,184,900.00	78,798,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,107,300.00	8,294,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,485,900.00	6,635,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,621,400.00	1,032,936.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,214,800.00	17,227,964.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,755,950.00	41,500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,985,042.00	10,000,000.00
210302	Түлш, халаалт	31,013,150.00	30,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	757,758.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,866,951.60	29,265,887.82
210401	Бичиг хэрэг	5,317,300.00	7,333,437.82
210402	Тээвэр, шатахуун	10,513,884.00	15,497,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	483,600.00	517,600.00

210404	Ном, хэвлэл	345,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,642,250.00	5,917,450.00
210408	Бараа материал акталсны зардал	12,564,417.60	00.00
2105	Нормативт зардал	23,907,796.02	30,476,005.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	1,823,400.00
210502	Хоол, хүнс	21,393,730.02	28,652,605.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,514,066.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,935,100.00	3,666,400.00
210604	Урсгал засвар	3,935,100.00	3,666,400.00
2107	Томилолт, зочны зардал	220,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	220,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,517,700.00	6,108,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,017,700.00	5,288,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	820,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,341,726.44	101,494,551.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,184,000.50	3,246,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,157,725.94	98,247,651.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,443,254.58	34,360,522.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,494,280.00	32,577,115.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,456,780.00	32,577,115.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,037,500.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,948,974.58	1,773,307.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,948,974.58	1,773,307.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	10,100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	113,231,813.70	987,760,049.44
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	47,676,243.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	47,676,243.52
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-47,676,243.52
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	113,231,813.70	940,083,805.92

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,063,809,088.69	409,439,860.35	87,732,098.66	1,560,981,047.70
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,063,809,088.69	409,439,860.35	87,732,098.66	1,560,981,047.70

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	41,753,198.00	41,753,198.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,063,809,088.69	409,439,860.35	129,485,296.66	1,602,734,245.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-41,753,198.00	00.00	-41,753,198.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	940,083,805.92	940,083,805.92
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,063,809,088.69	367,686,662.35	1,069,569,102.58	2,501,064,853.62

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,145,911,300.00	1,136,772,988.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,077,453,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	2,174,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,174,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,174,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	1,075,279,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	1,075,279,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,145,911,300.00	59,319,688.82
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,058,408,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,174,000.00	4,933,588.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,933,588.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,174,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,329,100.00	54,386,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,329,100.00	54,386,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,109,990,300.00	1,101,004,388.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,109,990,300.00	1,101,004,388.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,058,742,245.42	1,066,984,581.82

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	814,494,794.92	828,969,893.00
210101	Үндсэн цалин	684,179,511.00	560,157,999.00
210102	Нэмэгдэл	69,885,630.00	214,779,670.00
210104	Урамшуулал	60,429,653.92	54,032,224.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,626,900.00	111,977,500.00
210201	Тэтгэврийн даатгал	75,197,500.00	78,798,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,107,300.00	8,294,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,485,900.00	6,635,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,621,400.00	1,659,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,214,800.00	16,589,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,742,800.00	31,490,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,985,042.00	10,000,000.00
210302	Түлш, халаалт	40,000,000.00	19,990,000.00
210303	Цэвэр, бохир ус	757,758.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,606,300.00	16,171,567.00
210401	Бичиг хэрэг	733,600.00	497,600.00
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.00	5,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	483,600.00	517,600.00
210404	Ном, хэвлэл	232,000.00	7,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,827,700.00	822,567.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,329,400.00	9,326,800.00
2105	Нормативт зардал	40,738,250.50	38,101,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,140,000.00	275,900.00
210502	Хоол, хүнс	23,636,950.50	36,441,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,961,300.00	1,384,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,386,300.00	28,040,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	5,154,000.00
210604	Урсгал засвар	5,586,300.00	22,886,000.00
2107	Томилолт, зочны зардал	220,000.00	746,400.00
210702	Дотоод албан томилолт	220,000.00	746,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,517,700.00	5,698,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,017,700.00	4,878,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	820,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,409,200.00	5,789,421.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,174,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,409,200.00	3,615,421.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,248,054.58	34,019,807.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,125,080.00	32,236,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,740,180.00	32,236,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,384,900.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,948,974.58	1,773,307.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,948,974.58	1,773,307.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,174,000.00	10,100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,174,000.00	10,100.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	35,921,000.00	35,768,600.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	35,921,000.00	35,768,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,921,000.00	35,768,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	35,921,000.00	35,768,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,921,000.00	35,768,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-35,921,000.00	-35,768,600.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,129,665,400.00	1,127,881,993.00	1,783,407.00	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,129,665,400.00	1,127,881,993.00	1,783,407.00	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,097,429,000.00	1,095,645,593.00	1,783,407.00	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	829,462,600.00	828,969,893.00	492,707.00	99.9
210101	Үндсэн цалин	575,750,800.00	560,157,999.00	15,592,801.00	97.3
210102	Нэмэгдэл	205,811,800.00	214,779,670.00	8,967,870.00	104.4
210104	Урамшуулал	47,900,000.00	54,032,224.00	6,132,224.00	112.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,977,500.00	111,977,500.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	78,798,900.00	78,798,900.00	00.00	100.0
210202	даатгал Тэтгэмжийн	8,294,700.00	8,294,700.00	00.00	100.0
210203	даатгал ҮОМШӨ-ний	6,635,600.00	6,635,600.00	00.00	100.0
210204	даатгал Ажилгүйдлийн	1,659,000.00	1,659,000.00	00.00	100.0
210205	даатгал Эрүүл мэндийн	16,589,300.00	16,589,300.00	00.00	100.0

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,500,000.00	31,490,000.00	10,000.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	10,000,000.00	10,000,000.00	00.00	100.0
210302	Түлш, халаалт	20,000,000.00	19,990,000.00	10,000.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,259,000.00	16,259,000.00	00.00	100.0
210401	Бичиг хэрэг	497,600.00	497,600.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	497,600.00	517,600.00	-20,000.00	104.0
210404	Ном, хэвлэл	414,600.00	414,600.00	00.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	522,400.00	502,400.00	20,000.00	96.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,326,800.00	9,326,800.00	00.00	100.0
2105	Нормативт зардал	39,382,300.00	38,101,700.00	1,280,600.00	96.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	276,700.00	275,900.00	800.00	99.7
210502	Хоол, хүнс	37,721,000.00	36,441,200.00	1,279,800.00	96.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,384,600.00	1,384,600.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,886,100.00	62,886,000.00	100.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,900,000.00	30,900,000.00	00.00	100.0
210602	Тавилга	9,100,000.00	9,100,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	22,886,100.00	22,886,000.00	100.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	746,400.00	746,400.00	00.00	100.0
210702	Дотоод албан томилолт	746,400.00	746,400.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,898,100.00	1,898,100.00	00.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,078,100.00	1,078,100.00	00.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	820,000.00	820,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3317000.00	3317000.00	00.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,317,000.00	3,317,000.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32236400.00	32236400.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,236,400.00	32,236,400.00	00.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,236,400.00	32,236,400.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,129,665,400.00	1,127,881,993.00	1,783,407.00	99.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,075,279,300.00	1,073,505,993.00	1,773,307.00	99.8

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,075,279,300.00	1,073,505,993.00	1,773,307.00	99.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,386,100.00	54,376,000.00	10,100.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	54,386,100.00	54,376,000.00	10,100.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	77.00	77.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	33.00	33.00	00.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	568.00	568.00	00.00	100.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	568.00	568.00	00.00	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	568.00	568.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		7,107,588.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,107,588.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,107,588.82
2104	Хангамж, бараа материалын зардал		320,167.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		320,167.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2487421.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,174,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		313,421.82
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	7,107,588.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		7,107,588.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,933,588.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,174,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Лхагвадорж, аудиторын туслах Д.Балжинням нар гүйцэтгэж, хяналтыг аудитын чанарын менежер Д.Гэрэлчулуун, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2021 оны 12 дүгээр сарын 31-ны өдрийн 106 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлан нийт зардлын 1,157.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 23,1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17,3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 307,255.9 сая төгрөгөөр буюу 40,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	4.2	0,0	-4.2
Бараа материал	153.0	173.0	20.0
Биет хөрөнгө	1,344.2	2,269.7	925.5
Биет бус хөрөнгө	59,6	58,3	-1,3
Нийт хөрөнгө	1,561.0	2,501.0	940.0
Хуримтлагдсан үр дүн	87,7	1,069.6	981.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,561.0	2,501.0	940.0

Бараа материалын дансны үлдэгдэл 173.0 сая төгрөг болж 20.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Урсгал засварын материал, хоолны материал зэрэг бараа авсан нь үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2.269,7 сая төгрөг болж 925.5 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 977.7 сая төгрөгийн өртөгтэй 240 хүүхдийн хичээлийн байр шинээр орлого авсан, машин тоног төхөөрөмж дансанд төсвийн хөрөнгөөр 25.4 сая төгрөг, хөрөнгө оруулалтаар 23.3 сая төгрөг, тавилга аж ахуйн эд хогшил дансанд төсвийн 9.4 сая төгрөг, хөрөнгө оруулалтаар 22.4 сая төгрөг, номын фондод төсвийн хөрөнгөөр 0.4 сая төгрөг, программ хангамж дансанд төсвийн хөрөнгөөр 0.1 сая төгрөгийн орлогыг тус тус авч, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор нийт 184.6 сая төгрөгийн хөрөнгүүдийн акталсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,501.0 сая төгрөг болж 929,0 сая төгрөгөөр өссөн нь 240 хүүхдийн шинэ барилга болон үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийн дүн зэрэг нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь Улсын төсвийн санхүүжилт 16,9 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй орлого 1,032.0 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 32.7 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Урсгал засврын зардал, Бараа материал акталсны зардал, элэгдлийн зардлууд 14.1 сая төгрөгөөр өсч, Ашиглалтын болон нормативт зардал, Цалин, НДШ-ийн зардлууд 18.6 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээтэй хөрөнгө хасагдсантай холбоотой 360.8 сая төгрөгөөр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр хуримтлагдсан үр дүнд өөрчлөлт орсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,399.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,399.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 25.6 сая төгрөгөөр бууруулж 1.374,3 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ төсвийн жилд батлагдсан төсөвт 2 удаа тодотгол, зохицуулалтыг хийж, тайлант жилийн нөхцөл байдалтай уялдуулан хүүхдийн хоолны зардал, хичээл үйлдвэрлэлийн зардал, тогтмол зардлуудаас нийт 22,8 сая төгрөг тус тус хасаж, Эд хогшил авах зардалд 20.7 сая төгрөг, Шатахууны зардалд 0.5 сая төгрөг, Эм бэлдмэл зардалд 0.05 сая төгрөг Аудитын төлбөрт 0.06 сая төгрөг, Нэг удаагийн тэтгэмжийн зардалд 0.03 сая төгрөг, төлбөр хураамж бусад зардалд 0.02 сая төгрөг нийт 22,8 сая төгрөгийг нэмж, тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургууль тайлант онд төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,075.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 54.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,127.9 сая төгрөгийг зарцуулж 1.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,127.9 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь Хоолны зардлыг дутуу зарцуулсантай холбоотой байна.

71801 буюу Ерөнхий боловсролын хөтөлбөрийн хүрээнд 5 зориулалт арга хэмжээнд зарцуулсан гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл :

Зориулалт, арга хэмжээний код	Арга хэмжээний нэр	Төсөв	Гүйцэтгэл	зөрүү	Тайлбар
-------------------------------	--------------------	-------	-----------	-------	---------

81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	628.4	628.4	0.00	
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	298.5	298.5		00
80109	ТШЗ ийн байгууллагуудын тогтмол зардал	54.5	54.2	0.3	төвлөрүүлсэн
81807	Дотуур байрны хүүхдийн хоол	116.0	115.8	0.2	төвлөрүүлсэн
80801	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж дэмжлэг	32.2	30.9	1.3	төвлөрүүлсэн
Дүн		1,129.6	1,127.9	1.8	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд Аймгийн боловсролын газраас 7.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Нэмэлтээр ирсэн санхүүжилтийн 7.1 сая төгрөгөөр бараа материалын тайланд ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд болон хичээл үйлдвэрлэл, бараа үйлчилгээний бусалд зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулгад онцлох асуудлын талаар мэдээлэл тусгаагүй байна.

Тайлант онд Ковид-19 цар тахлын улмаас сургуулийн үйл ажиллагаа тасралтгүй байх зарчим алдагдсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын явцад үлэмж нөлөө үзүүлэх асуудал үүсээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн шууд захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д зааснаар, хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээлэлээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Монгол Улсын Засгийн газрын “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 237 дугаар тогтоолын 1-д “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1500 (нэг мянга таван зуун) төгрөгөөр тогтоосугай.” гэж, 2-д “...6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1800 (нэг мянга найман зуун) төгрөг байхаар тогтоож...” гэж тус тус заасныг мөрдөн ажилласан байна. Мөн Засгийн газрын “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 2-т “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 (Гурван мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай.” гэж заасныг дагаж мөрдөж байна.
- Тайлант хугацаанд “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл, “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж, "11.7" хувь, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж, "11.5" хувь болж өөрчлөгдсөн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, акт , албан шаардлага байхгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар гарсан алдаа зөрчилд 4 зөвлөмж, 1 залруулга хийлгэсэн болно.

4.1 Залруулсан алдаа

4.1.1. Аудитын гүйцэтгэлийн шатанд Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний дүн буруу байсныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага тавиагүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны мэдээлэлтэй Холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Шилэн дансанд байршуулсан мэдээллүүд нь хугацаандаа шивж оруулсан боловч мэдээний чанар, гүйцэтгэл муу байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 заалтыг хэрэгжүүлэх. Иж бүрэн байх батламж мэдэгдлийг зөрчиж байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Бодлогын баримт бичигтэй холбоотой

2.1. **Илрүүлэлт:** Байгууллагаас авсан санал асуулга, журналын бичилтээс харахад өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан бодлогын баримт бичиг боловсруулж батлуулаагүй байна. Толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. **Өгсөн зөвлөмж:** Бодлогын баримт бичгийг шинээр боловсруулж, мөрдөж ажиллах.

3. Бараа ажил үйлчилгээний баримтын бүрдэлтэй холбоотой

3.1. **Илрүүлэлт:** Баримтыг түүвэрчлэн тулгахад харилцагч байгууллагын нэхэмжлэх, зарлага, орлогын падаан байгаа боловч э-баримтгүй байна. Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1 **Өгсөн зөвлөмж:** Э-баримт болон бусад баримтын бүрдэл болсон гүйлгээг хийж, зөрчлийг дахин давтахгүй байна.

4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

4.1. **Илрүүлэлт:** Элэгдлээ бүрэн нөхсөн, 00 үлдэгдэлтэй 44 төрлийн 74 ширхэг үндсэн хөрөнгийн ашиглах жил болон үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. Үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. **Өгсөн зөвлөмж:** 2022 оны эхний хагас жилд багтаан холбогдох газарт материалыг бүрдүүлэн өгч, тайлан балансад тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС
ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

АУДИТОР

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИАС
ХЯНАСАН:

Чанарын менежер

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Огноо:

Э.БАТ-ЭРДЭНЭ

Огноо:

С.Гансүх

Огноо:

Д.Гэрэлчулуун

Огноо:

Б.Лхагвадорж

Огноо: